

52

БАТЛАВ:

2014 оны 06 сарын 10 -ны өдөр



## БРОКЕР ДИЛЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ДОТООД ЖУРАМ

*Нэг. Нийтлэг үндэслэл*

- 1.1 Энэхүү журмаар Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх “БиДиСек” ҮЦК-иас харилцагчид үзүүлэх үнэт цаасны зуучлалын үйлчилгээ болон компани өөрийн хөрөнгөөр үнэт цаасны арилжаанд оролцохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

*Хоёр. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР*

- 2.1 Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
- 2.1.1 “**ҮЦК**” гэдэгт брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх “БиДиСек” ХК-ийг;
  - 2.1.2 “**Брокер**” гэдэгт ҮЦК-ийн үнэт цаасыг худалдах, худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээний хүрээнд харилцагчдад үйлчилж буй мэргэжилтнийг;
  - 2.1.3 “**Харилцагч**” гэдэгт ҮЦК-тай байгуулсан үнэт цаасыг худалдах, худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээний гэрээний хүрээнд үйлчлүүлж буй хувь хүн, хуулийн этгээдийг;
  - 2.1.4 “**ҮЦТТХТ**” гэдэгт үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий төрийн өмчит хуулийн этгээдийг;
  - 2.1.5 “**Төлбөр тооцоо гүйцэтгэгч**” гэж ҮЦК-тай байгуулсан гэрээний хүрээнд үнэт цаасны арилжааны мөнгөн төлбөр тооцоог гүйцэтгэж буй банкийг;
  - 2.1.6 Харилцагчийн “**арилжааны данс**” гэж Харилцагч нь зөвхөн өөрийн үнэт цаасны арилжааны мөнгөн төлбөрийг гүйцэтгүүлэх зорилгоор Төлбөр тооцоо гүйцэтгэгчид тусгайлан нээсэн дансыг;

- 2.1.7 Харилцагчдын арилжааны “**номинал данс**” гэдэгт харилцагчдын мөнгөн хөрөнгийг нэгтгэн мөнгөн хөрөнгийн гүйлгээ болон үнэт цаас худалдах, худалдан авах арилжааны үнийн дүнд үүссэн төлбөр тооцоог хийх зориулалтаар ҮЦК-ийн нэр дээр Төлбөр тооцоо гүйцэтгэгчид нээсэн дансыг;
- 2.1.8 “**Номинал харилцагч**” гэдэгт ҮЦК-тай байгуулсан гэрээний хүрээнд өөрийн мөнгөн хөрөнгийг номинал дансанд байршуулан арилжааны төлбөр тооцоо, мөнгөн гүйлгээг ҮЦК-иар гүйцэтгүүлэх хувь хүн, хуулийн этгээдийг;

*Гурав. БРОКЕР ДИЛЕРИЙН КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ*

- 3.1 ҮЦК нь хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны зах зээлийн шударга байдлыг хангах үүднээс дараах зарчмыг баримталж ажиллана.
- 3.1.1 Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос (цаашид Хороо гэх) баталсан дүрэм, журмыг мөрдөж ажиллах;
- 3.1.2 Хороо, арилжаа эрхлэх байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай боловсон хүчин, санхүү болон техник технологитой байх;
- 3.1.3 Харилцагчтай нэмэлт нөхцлөөр зуучлалын үйлчилгээний гэрээ байгуулахдаа харилцагчаа таньж судалсан байх;
- 3.1.4 Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардагдах мэдээлэл, зөвлөгөөгөөр харилцагчийг хангах;
- 3.1.5 Харилцагчийн ашиг сонирхлыг дээгүүр тавьж, албан үүргээ гүйцэтгэх явцад олж авсан мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх;
- 3.1.6 Харилцагчийн хөрөнгийг компанийн хөрөнгөөс тусгаарлан, найдвартай байдлыг хангаж ажиллах;
- 3.1.7 Үйл ажиллагаатай холбоотой анхан шатны баримтыг стандартын дагуу хөтөлж, хадгалах;
- 3.1.8 Дотоод хяналтын тогтолцоотой байх;

*Дөрөв. ХАРИЛЦАГЧТАЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭ*

52

- 4.1 ҮЦК нь харилцагчдадүнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйлчилгээг үзүүлэх зорилгоор түүний нэрийн өмнөөс “ҮЦТТТХТ” ХХК-ийн төвлөрсөн хадгаламжид данс нээлгэнэ.
- 4.2 Харилцагчийн дансыг нээхдээ дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:
  - 4.2.1 Иргэн бол:
    - данс нээх гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбар, түүнтэй адилтгах бичиг баримт, банкны дансны дугаар,
  - 4.2.2 Насанд хүрээгүй хүүхэд бол төрсний гэрчилгээ болон эцэг/эхийн иргэний үнэмлэх;
  - 4.2.3 Хуулийн этгээд бол:
    - данс нээлгэх тухай албан хүсэлт, улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, банкны дансны дугаар, хуулийн этгээдийн уг дансан дахь хөрөнгийг захиран зарцуулах этгээдийг томилсон тухай эрх бүхий этгээдийн тодорхойлолт;
  - 4.2.4 Өөрийн биеэр хүрэлцэн ирэх боломжгүй дотоод болон гадаад иргэн нь иргэний үнэмлэх эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг, хуулийн этгээдийн хувьд бүртгэлийг тухайн улсын нотариатчаар гэрчлүүлсэн бичиг баримт;
  - 4.2.5 Данс нээлгэх хураамж:
    - Иргэд 5,000₮
    - Хуулийн этгээд 50,000₮
- 4.3 Данс нээх гэрээ нь уг гэрээг цуцлах нөхцөл, эрх үүрэг, хариуцлагыг тусган 3-н хувь үйлдэж, /Харилцагч, ҮЦК, “ҮЦТТТХТ” ХХК/ харилцагч, компанийн гүйцэтгэх захирал нар гар үсэг зурснаар уг гэрээ хүчин төгөлдөр болно. Гэрээний нэг хувийг ҮЦК архивлан хадгална.
- 4.4 Харилцагчийн төлбөр гүйцэтгэх банкны дансыг (цаашид арилжааны данс гэх) ҮЦК нь шаардлагатай бичиг баримтыг харилцагчаас бүрдүүлэн арилжааны данс нээлгэх ажлыг гүйцэтгэж болно. ҮЦК нь харилцагчийн арилжааны дансыг нээхдээ Хорооны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журам”-ын 4.2.1, 4.2.2, 4.2.3, 4.3-т заасныг баримтална.
- 4.5 ҮЦК нь харилцагчтай байгуулсан гэрээг үндэслэн тухайн харилцагчийн талаар дараах мэдээллийг харилцагчийн ерөнхий бүртгэлд бүртгэнэ. Үүнд:

- 55
- 4.5.1 Харилцагч иргэн бол овог, нэр, регистрийн дугаар, гадаадын иргэн бол гадаад паспортын дугаар, албан ёсны болон оршин суугаа хаяг, утасны дугаар;
  - 4.5.2 Харилцагч хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, хаяг, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн овог, нэр, регистрийн дугаар, утасны дугаар, гадаадын иргэн бол гадаад паспортын дугаар;
  - 4.6 Компани нь 2.1.3-д заасан нэмэлт нөхцөлтэй зуучлалын үйлчилгээ үзүүлэх тохиолдолд тухайн харилцагчтай Тел-е үйлчилгээний гэрээг байгуулна. Уг гэрээг тусгайлсан журмаар зохицуулна.

*Тав. ХАРИЛЦАГЧИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ*

- 5.1 ҮЦК нь харилцагчдад үнэт цаас худалдах, худалдан авах талаар шийдвэр гаргахад шаардлагатай дараах мэдээллээр хангах үүргийг хүлээнэ. Үүнд:
  - 5.1.1 Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гаргасан үнэт цаасны сүүлийн 6 сарын арилжааны идэвхи, үнэ ханш, арилжаатай холбоотой нийтэд мэдээлэхийг хуулиар хориглоогүй бусад мэдээлэл.
  - 5.1.2 Үнэт цаас гаргагчийн хаяг, ерөнхий болон санхүүгийн байдлын талаарх мэдээлэл /Үүнд тухайн үнэт цаас гаргагчаас нийтэд мэдээлэхээр заасан санхүүгийн мэдээллүүд хамаарна/;
  - 5.1.3 Үнэт цаасны арилжаанд оролцохтой холбоотой данс нээлгэх, захиалга өгөх заавар, гарын авлага;

*Зургаа. ХАРИЛЦАГЧДАД МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ*

- 6.1 Харилцагчтай гэрээ байгуулахын өмнө Брокер нь үнэт цаасны зах зээлийн талаарх ерөнхий ойлголт өгөх зорилгоор дараах мэдээллийг танилцуулна.
  - 6.1.1 Үнэт цаасны арилжааны захиалга, хэлцэл хийгдэх явц, электрон арилжааны системийн талаар,
  - 6.1.2 Үнэт цаас худалдах, худалдан авахад хүлээж болох зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэл,
  - 6.1.3 Компанийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны тав букуу түүнээс дээш хувийг худалдан авсан этгээд уг үнэт цаасыг худалдан авснаас хойш ажлын

арав хоногийн дотор Хороонд мэдэгдэх зэрэг хуулийн дагуу үүсэх үүрэг хариуцлагууд.

- 6.2 Брокер нь харилцагчийн өгсөн захиалга биелэгдсэн тохиолдолд үнэт цаасны нэр, үсгэн код, хэлцэл хийгдсэн огноо, үнэ, тоо ширхэг, шимтгэлийн талаарх мэдээллийг гэрээнд заасан цахим шуудан, утас, факс, бусад боломжит харилцаа холбооны хэрэгслээр нэн даруй мэдэгдэнэ.
- 6.3 ҮЦК нь харилцагч шаардсан тохиолдолд харилцагчийн дансны хуулгыг цахим шуудангаар явуулах эсхүл харилцагч нууц үгийн тусламжтай онлайнгаар өөрийн дансыг шууд хянах боломжоор хангана.
- 6.4 ҮЦК нь харилцагчийн шаардсанаар өөрийн компанийн талаар дараах баримт мэдээллээр хангах үүрэгтэй. Үүнд:
  - 6.4.1 Тухайн компанийн үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл болон улсын бүртгэлийн гэрчилгээтэй холбогдсон бичиг баримт;
  - 6.4.2 Компанийн санхүүгийн байдлын талаарх мэдээлэл;
  - 6.4.3 Гүйцэтгэх захирал, дотоод хяналтын ажилтан, мэргэжилтнүүд нь мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотойгоор арга хэмжээ авагдсан, хариуцлага хүлээсэн эсэх тухай мэдээлэл.
- 6.5 ҮЦК нь өөрийн цахим хуудас болон харилцагчдын мэдээлэл авахаар бүртгүүлсэн цахим шуудангаар дараах мэдээллийг тогтмол хүргэж ажиллана. Үүнд:
  - 6.5.1 Хувьцааны тухайн өдрийн ханш;
  - 6.5.2 МХБ-ийн арилжааны мэдээ;
  - 6.5.3 Хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээ мэдээлэл;
  - 6.5.4 Хувьцаат компанийн талаарх мэдээлэл;
  - 6.5.5 Холбогдох хууль журам;
  - 6.5.6 Шинээр гарч буй үнэт цаасны мэдээлэл;

*Долоо. ХАРИЛЦАГЧИЙН ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ*

- 7.1 Брокернь харилцагчийн захиалгыг гэрээнд заасан нөхцлийн дагуу гүйцэтгэх үүрэгтэй бөгөөд нөхцөл өөрчлөгдөх тохиолдолд энэ тухай харилцагчид мэдэгдэх үүрэгтэй.

- 7.2 Захиалга өгч буй этгээд тухайн дансанд буй эд хөрөнгийг хууль ёсоор захиран зарцуулах эрхтэй эсэхийг Брокер урьдчилан шалгаж, уг харилцагчид захиалгыг биелүүлэх электрон арилжааны талаар танилцуулсны үндсэн дээр захиалгыг хүлээн авна.
- 7.3 Захиалга өгөх харилцагч нь иргэн бол тухайн дансанд буй үнэт цаасны хууль ёсны данс эзэмшигч, хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, эсхүл тэдгээрийг хууль ёсоор төлөөлөх этгээд байна. Насанд хүрээгүй хүүхдийн дансаар гүйлгээ хийх тохиолдолд данс эзэмшигчийн хууль ёсны төлөөллийг нотлох бичиг баримт байна.
- 7.4 ҮЦК нь дилерийн үйл ажиллагаа давхар эрхэлж байгаа эсэхээс үл хамаарч харилцагчийн даалгаврыг тэргүүн ээлжид биелүүлэх, харилцагчдын захиалгыг өгсөн хугацааны дарааллын дагуу гүйцэтгэнэ.
- 7.5 Брокер нь харилцагчийн захиалгыг хүлээн авахаас өмнө сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар урьдчилан мэдэгдэх, захиалга хүлээн авсны дараа сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухай харилцагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
- 7.6 Сонирхлын зөрчлийн талаар мэдэгдээгүйн улмаас үүсэх хохирлыг тухайн холбогдох этгээд хариуцна.
- 7.7 Брокер нь харилцагчийн захиалгыг хүлээн авч тухайн захиалгыг бичгээр, эсхүл дуу болон дүрст бичлэгээр баталгаажуулан захиалгын нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.
- 7.8 Брокер нь харилцагчтай байгуулах захиалгын баримтад дараах нөхцөлийг тусгасан байна. Үүнд:
- 7.8.1 Үнэт цаасны нэр, код;
  - 7.8.2 Үнэт цаасны тоо ширхэг;
  - 7.8.3 Захиалгын нөхцөл, тодотгол, хүчинтэй байх хугацаа;
  - 7.8.4 Хүчинтэй хугацааг заагаагүй буюу тодотголгүй захиалгын хувьд тухайн захиалга ажлын нэг хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7.9 Захиалгыг утсаар, цахим шуудан болон цахим хэлбэрээр авах харилцааг ҮЦК нь "Тел-и үйлчилгээний журам"-аар зохицуулна.
- 7.10 Бичгээр өгсөн захиалгын гэрээг гүйцэтгэх захирлын баталсан маягтын дагуу хоёр хувь үйлдэх бөгөөд харилцагч болон ҮЦК тус бүр нэг хувийг хадгална.
- 7.11 Бичгээр өгсөн захиалгын гэрээнд дараах зүйлсийг тусгана. Үүнд:

- 7.11.1 Иргэн бол нэр, регистрийн дугаар, дансны дугаар /префикс дугаар /, гадаад паспортын дугаар /гадаад иргэн бол/, гарын үсэг, утасны дугаар, гэрийн хаяг, брокерийн нэр, гарын үсэг, гэрээ байгуулсан огноо, цаг минут;
- 7.11.2 Хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, дансны дугаар /префикс дугаар/, төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг, нэр, албан тушаал, утасны дугаар, хаяг, тамганы дардас, брокерийн нэр, гарын үсэг, гэрээ байгуулсан огноо, цаг минут;
- 7.12 Үнэт цаас худалдах, худалдан авах ердийн захиалга нь хуанлийн 30 өдөр хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 7.13 Үнэт цаас худалдах худалдан авах үйлчлэх хугацааг заасан захиалга нь дараах нөхцөлтэй байна. Үүнд:
  - 7.13.1 GTC-Захиалга цуцлагдах хүртлээ эсвэл хуанлийн 30 өдөр хүчинтэй байна.
  - 7.13.2 GTT- Тухайн арилжааны өдрийн заасан цаг хүртэл хүчинтэй байна.
  - 7.13.3 GTD-Хэлцэл хийгдээгүй тохиолдолд захиалга нь заасан арилжааны өдөр дуусахад хүчингүй болно. *Ихдээ хуанлийн 30 өдөр хүчинтэй!*
  - 7.13.4 DAY-Өдрийн захиалга бөгөөд тухайн өдрийн арилжааны цаг дуусах хүртэл хүчинтэй.
- 7.14 Брокер нь үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийг зөрчих нөхцөлтэй харилцагчийн захиалгыг хүлээн авах, биелүүлэхээс татгалзах эрхтэй.
- 7.15 Харилцагч биечлэн ирж захиалга өгөх боломжгүй бол түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч аливаа гүйлгээг хийх, захиалга өгөх эрхтэй. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь нотариатаар баталгаажуулсан итгэмжлэлийг үндэслэн аливаа гүйлгээг хийнэ.

*Найм. ЗАХИАЛГА БИЕЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА*

- 8.1 Харилцагчийн захиалгыг хүлээн авсан Брокер нь захиалгыг Улаанбаатар хотод ажлын нэг өдөр, орон нутагт ажлын гурван өдөрт багтааж дилерийн даалгаварт тусгуулан, арилжааны брокерт шилжүүлнэ.
- 8.2 ҮЦК-ийн салбар нь тухайн салбарыг илэрхийлсэн кодын дагуу захиалгын гэрээг дугаарлана.
- 8.3 Брокер нь харилцагч цахим хэлбэрээр үнэт цаасны арилжаанд оролцохоос бусад бүх захиалгыг үнийн болон цаг хугацааны дарааллаар нэгтгэн арилжаа эхлэхээс нэг

цагийн өмнө дилерийн даалгаварт тусгана. Харилцагч захиалгад өөрчлөлт оруулсан бол уг захиалгыг хүлээн авсан Брокер арилжааны брокерт мэдэгдэн зохих өөрчлөлтийг нэн даруй оруулна.

- 8.4 Нээлтийн дуудлага арилжааны үед оруулсан захиалгууд нь дуудлага арилжааны алгоритмын дагуу, энгийн арилжааны үед оруулсан захиалгууд нь ханшийн болон цаг хугацааны эрэмбэ дарааллын дагуу биелэгдэнэ.
- 8.5 Ижил нөхцөлтэй захиалгыг үнэт цаас худалдан авахад үнийн дээд, худалдахад үнийн доод хэмжээг үндэслэнэ. Харин үнэ тэнцсэн тоххиолдолд хугацааны дарааллаар тус тус биелэгдэнэ.
- 8.6 Харилцагчийн хойшлуулах болзолтойгоор өгсөн захиалгын баримтад заасан нөхцөл бий болж, эрх үүрэг нь үүссэний дараа компани нь захиалгыг дилерийн даалгаварт тусгана. Энэ хүртэл компани нь хойшлуулах болзолтойгоор өгсөн захиалгыг бүртгэж, болзолд заасан нөхцөл бий болсон эсэхэд байнга хяналт тавина.

*Ес. ХАРИЛЦАГЧИЙН ЗАХИАЛГЫГ ӨӨРЧЛӨХ, ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛГОХ*

- 9.1 Харилцагч нь өөрийн биелэгдээгүй захиалгыг арилжааны холбогдох үе шатанд цуцлах, эсхүл тухайн захиалгын нөхцөлийг өөрчлөх бол брокерт мэдэгдэж гэрээнд өөрчлөлт оруулна.
- 9.2 Брокер харилцагчийн захиалга цуцлах, өөрчлөх хүсэлтийг хүлээн авч гэрээнд тэмдэглэл хийн, шинээр үүссэн захиалгын даалгаврыг арилжааны брокерт шилжүүлж гүйцэтгэх үйл ажиллагааг эхлүүлнэ.
- 9.3 Харилцагчийн захиалга дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
  - 9.3.1 Захиалга бүрэн биелэгдсэн;
  - 9.3.2 Зах зээлийн захиалгын хувьд гэрээнд заасан үнэт цаасыг худалдан авах мөнгөний дээд хэмжээнд хүрсэн, арилжааны дансанд байршуулсан мөнгө дууссан;
  - 9.3.3 Энэ журмын 7.12 болон 7.13-д заасан захиалгын гэрээний үйлчлэх хугацаа дууссан;
  - 9.3.4 Харилцагч үнэт цаасны таван удаагийн арилжааны явцад өөрийн захиалгыг биелүүлэхгүй байхыг хүссэн тохиолдолд үнэт цаасны арилжаанд орохоос татгалзсан сүүлчийн өдрөөр тасалбар болгон;



60

9.4 Брокер нь арилжаанд тогтмол оролцдог харилцагчийн дансаар хийгдэх гүйлгээ нь үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг зөрчиж буй эсэхэд хяналт тавих үүрэгтэй. Үүнд:

9.4.1 Харилцагч хууль дүрэм зөрчсөн үйлдэл байж болзошгүй захиалгыг оруулахаас татгалзаж энэ тухай арилжаа эрхлэх байгууллага болон Хороонд мэдэгдэх;

9.4.2 Харилцагч үнэт цаасны зах зээлийн тухай хууль, тогтоомжийг зөрчсөнийг илрүүлсэн тохиолдолд тухайн өдрөөс хойш ажлын 1 хоногийн дотор Хороонд мэдэгдэх;

*Арав. ХАРИЛЦАГЧИЙН МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЗОХИЦУУЛАЛТ*

10.1 Харилцагч үнэт цаас худалдах, худалдан авах арилжааны төлбөр тооцоог төлбөр тооцоо гүйцэтгэгчид нээлгэсэн арилжааны дансаар хийж гүйцэтгэнэ.

10.2 Харилцагчийн арилжааны дансны нарийвчилсан харилцааг ҮЦК, төлбөр тооцоо гүйцэтгэгч банк, харилцагч нарын хооронд байгуулсан гурвалсан гэрээгээр зохицуулна.

10.3 Өөрийн нэр дээр арилжааны данстай харилцагч үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгийг уг дансанд байршуулна.

10.4 Номинал харилцагч нь ҮЦК-ийн харилцагчдын нэгдсэн номинал дансанд байршуулна.

10.5 Харилцагч өөрийн арилжааны болон үнэт цаасны данснаас мөнгөө эргүүлэн татахдаа мөнгө хүссэн маягыг бөглөн иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээд бол захиран зарцуулах этгээдийн иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсарган, гарын үсэг зурж тамга дарсан байна.

10.6 Брокер харилцагчаас мөнгө хүссэн маягыг хүлээн авч бүрдүүлбэрийг шалган зохих бичилт, тамга дарж баталгаажуулан холбогдох байгууллага /ҮЦТТХТөв ХХК, төлбөр тооцоо гүйцэтгэгч банк/-д хүргүүлснээр харилцагчийн данснаас мөнгө гаргах үйл ажиллагаа хийгдэнэ.

10.7 Мөнгө шилжүүлэхэд ҮЦК нь ямарваа шимтгэл хураамж авахгүй бөгөөд Харилцагч зөвхөн банкны шилжүүлгийн хураамж төлнө.

61

10.8 Номинал дансны мөнгөн гүйлгээ, бүртгэлтэй холбоотой нарийвчилсан харилцааг холбогдох журмаар зохицуулна.

*Арван нэг. КОМПАНИЙН ХӨРӨНГӨӨР ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД ОРОЛЦОХ*

11.1 Компани нь гүйцэтгэх захиралын шийдвэрээр өөрийн хөрөнгөөр үнэт цаас худалдах, худалдан авах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

11.2 Гүйцэтгэх захирлын шийдвэрийг үндэслэн Хорооны “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журам”-ын 2-р хавсралтаар батлагдсан маягтын дагуу арилжаанд оролцох бөгөөд арилжааны явцад үнэт цаас худалдах, худалдан авах шийдвэрийг гаргах эрхийг гүйцэтгэх удирдлагаас дилерт олгож болно.

11.3 Дилер нь энэ журмын 9.2-т заасан шийдвэрийг гаргасан бол энэ тухай дилерийн даалгаварт тухай бүр тэмдэглэн, удирдлагуудад танилцуулна.

11.4 Компани нь өөрийн хөрөнгөөр үнэт цаас худалдах, худалдан авах дараах нөхцлийг тусгасан дилерийн даалгаврыг арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ. Үүнд:

11.5 Худалдах, худалдан авах үнэт цаасны үнэ, тоо ширхэг

11.6 Худалдах, худалдан авахаар санал болгож буй үнийн хүчинтэй байх хугацаа

11.7 Дилер нь дээрх журмын 9.4-д заасан нөхцлийг арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу өөрчлөх буюу цуцалж болох бөгөөд дилерийн үнэт цаас худалдах, худалдан авах нөхцлийг зөвшөөрсөн тохиолдолд тэрээр үл маргах журмаар биелүүлэх үүрэгтэй.

11.8 Үнэт цаас худалдах, худалдан авахдаа ҮЦК нь харилцагчийн захиалгыг бүрэн биелүүлсний дараа өөрийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн захиалгыг биелүүлнэ.

*Арван хоёр. БРОКЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИМТГЭЛ*

12.1 Компани нь шинэ болон холболтын дансыг нээхэд тогтоох гүйлгээний шимтгэлийн хэмжээ нь 3% байна.

12.2 Компани нь харилцагчийн арилжааны идэвх, үнийн дүн зэргийг харгалзан “Компанийн шимтгэлийн хувь хэмжээг тогтоох, өөрчлөх тухай журам”-ыг үндэслэн өөрчлөн тогтоож болно.

*Арван гурав. ЗАР СУРТАЛЧИГАА*

- 13.1 ҮЦК нь үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах болон хоёрдогч зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, холбогдох үйлчилгээг санал болгохдоо нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон утас, интернет, цахим шуудан, хэвлэмэл хуудас зэрэг хэлбэрээр зар сурталчилгаа явуулж болно.
- 13.2 ҮЦК нь Зар сурталчилгааг бодит байдалд нийцүүлсэн байх ба төөрөгдүүлсэн, үндэслэлгүй мэдээлэл агуулаагүй байх зарчмыг баримталж ажиллана.
- 13.3 ҮЦК нь гуравдагч этгээдээс авсан аливаа мэдээллийг зар сурталчилгаандаа түүнийг үндэслэлтэй эсэхийг шалгасны үндсэн дээр иш татаж ашиглана.

*Арван дөрөв. БИЧИГ БАРИМТ ХАДГАЛАХ*

- 14.1 ҮЦК нь бичиг баримтыг хадгалах, архивын нэгж болгох нийтлэг харилцааг Монгол Улсын Архивын тухай хуулиар, нарийвчилсан харилцааг арилжаа эрхлэх байгууллага болон төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын дотоод журмаар зохицуулна.
- 14.2 ҮЦК нь дараах бичиг баримтыг өөрийн архивт таваас доошгүй жилийн хугацаагаар хадгална. Үүнд:
  - 14.2.1 Харилцагчтай байгуулсан данс нээх гэрээ, захиалгын гэрээ, Харилцагчаа таньж мэдэх маягт/Тел-и үйлчилгээний маягт, итгэмжлэл;
  - 14.2.2 Харилцагчийн ерөнхий мэдээллийн бүртгэл;
  - 14.2.3 Үнэт цаас худалдах, худалдан авах захиалгатай холбоотой бичиг баримт, дуу хоолойны болон дүрст бичлэг;
  - 14.2.4 Харилцагчийн мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой баримтууд;
  - 14.2.5 Компанийн холбогдох этгээд болон нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэл;
  - 14.2.6 Өөрийн данс дахь үнэт цаас, мөнгөн хөрөнгө, тэдгээртэй холбоотой хэлцлийн бүртгэл;
  - 14.2.7 Дотоод хяналт шалгалтын тайлан, дүгнэлт, түүний үр дүнд хийгдсэн ажлын тайлан, холбогдох бичих баримтууд;
  - 14.2.8 Харилцагчаас ирүүлсэн өргөдөл гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдал, тусгай зөвшөөрлийн болон Компанийн улсын бүртгэлтэй холбоотой бичиг баримт, гэрээ хэлцэл зэрэг бусад бичиг баримтууд;

Арван тав. ХОРИГЛОХ ЗҮЙЛ

- 15.1 ҮЦК-ийн мэргэжилтнүүд нь дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:
- 15.1.1 Үнэт цаасыг нийтэд худалдахаар санал болгох, үнэт цаасны арилжааны явцад харилцагчид хуурамч мэдээлэл өгөх, төөрөгдүүлэх;
  - 15.1.2 Дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, харилцагчдад хүргэх мэдээллийг нуун дарагдуулах, өгөхөөс татгалзах;
  - 15.1.3 Үнэт цаасны ханшийг бусадтай үгсэн хуйвалдаж зохиомлоор тогтоон барих, өсгөх, бууруулах үйлдэл хийх;
  - 15.1.4 Харилцагчийн өгсөн буюу өгөх гэж буй нь баттай мэдэгдэж буй захиалгыг хүлээн авч буй брокер, түүнийг мэдсэн ҮЦК-ийн мэргэжилтэн өөрийн дансаар тухайн үнэт цаасыг худалдах, худалдан авах, эсхүл гуравдагч этгээдийг худалдах, худалдан авахыг ятгах;
  - 15.1.5 Үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд тараагдаагүй дотоод мэдээллийг олж авсан этгээд өөрийн дансаар тухайн үнэт цаасыг худалдах, худалдан авах, эсхүл гуравдагч этгээдийг худалдах, худалдан авахыг ятгах;
  - 15.1.6 Харилцагчийн өмчлөлд байгаа үнэт цаасны тоо хэмжээ, түүнтэй холбогдох нийтэд тараагдаагүй мэдээллийг тараах, өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр сонирхогч этгээдэд уг үнэт цаасыг худалдан авахыг санал болгох;
- 15.2 Энэ журмын 14.1-д зааснаас гадна ҮЦК-ийн мэргэжилтнүүд нь үнэт цаасны арилжаа, төлбөрийн явцад дараах зүйлсийг хориглоно. Үүнд:
- 15.2.1 Биелүүлэх зорилгогүйгээр захиалгыг арилжааны програмд оруулах, түүнд засвар хийх, захиалга биелэгдэхээс өмнө цуцлах зэргээр тухайн үнэт цаасыг эрэлт нийлүүлэлттэй мэт зохиомлоор харагдуулах үйлдэл хийх;
  - 15.2.2 Харилцагчийн өгсөн үнэт цаас худалдах болон худалдан авах захиалгын хүчинтэй байх хугацааг харилцагчийн зөвшөөрөлгүй өөрчлөх;
  - 15.2.3 Арилжааны сүүлийн нэг цагийн туршид үнэт цаасны хаалтын ханшид нөлөөлөх зорилгоор худалдах, худалдан авах гүйлгээг хийх;
  - 15.2.4 Арилжаа эрхлэх байгууллагаас олгосон системд нэвтрэх нэр, нууц дугаарыг хууль бусаар бусдад дамжуулах;
  - 15.2.5 Харилцагчийн мөнгөн хөрөнгийг үл тусгаарлах, түүнийг төлбөрийн арилжааны болон номинал дансанд бүртгэлгүйгээр арилжаанд оролцуулах;

- 15.2.6 Хууль тогтоомжид заасан үндэслэлээр бизнесийн хэлцэл хийхийг хориглосон аливаа хуулийн этгээд, хувь хүнд данс нээх;
- 15.2.7 Арилжааны системийн мэдээллийн нууцлалыг алдагдуулах, урвуулан ашиглах;
- 15.3 ҮЦК нь дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:
- 15.3.1 ҮЦК нь хороонд бүртгүүлэлгүй гадаад улсын үнэт цаасны зах зээлээс үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг эрхлэх;
- 15.3.2 Тухайн үнэт цаасны арилжаа идэвхитэй явагдаж байгаа мэтээр олон нийтийг төөрөгдүүлэх зорилгоор брокер, дилерийн болон нэгдмэл сонирхолтой бусад этгээдийн хооронд давхар гүйлгээ хийх;
- 15.3.3 Үнэт цаасыг бүртгэх тухай Хорооны шийдвэр гарахаас өмнө үнэт цаасыг нийтэд санал болгох, сурталчлах;
- 15.3.4 Гэрээнд заасны дагуу үнэт цаас худалдан авахтай холбогдуулан ҮЦК нь харилцагчид зээл олгосноос бусад тохиолдолд компанийн болон харилцагчийн данс хооронд мөнгөн хөрөнгө шилжүүлэх;
- 15.3.5 Үнэт цаасны арилжааны явцад өмчлөгч нь өөрчлөгдөөгүй, нэгдмэл сонирхолтой этгээдийн хооронд үнэт цаасны үнэ, ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах зорилгоор гүйлгээ хийх;
- 15.3.6 Нийтэд тараагдаагүй дотоод мэдээлэл ашиглан өөрийн дансаар үнэт цаас худалдах, худалдан авах, эсхүл гуравдагч этгээдийг худалдах, худалдан авахыг ятгах;
- 15.3.7 Өрсөлдөөнийг хязгаарлах зорилгоор үнэт цаасны үнэ, арилжаалах нөхцөл, авах шимтгэлийн асуудлаар бусад ҮЦК-тай тохиролцох;

*Арван зургаа. ХАРИУЦЛАГА*

- 16.1 ҮЦК нь энэ журам болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн мэргэжилтэн, албан тушаалтанд компанийн дотоод журам болон Дотоод хяналтын журамд заасан хариуцлага ногдуулна.